



**ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2025 оны 02 дугаар сарын 07

Дугаар А/16

Баян-Өндөр сум


**Шагналын журам
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналын журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ш.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ

Албан хэрэгцээнд

615070055

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
даргын 2025 оны 02 дугаар сарын 07-ний
өдрийн 116 дугаар захирамжийн хавсралт

АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШАГНАЛЫН ЖУРАМ



Баримт бичгийн код: БҮЖ-14

Журмын агуулга:

- Нэг. Зорилго
- Хоёр. Хамрах хүрээ
- Гурав. Баримт бичгийн хариуцагч
- Дөрөв. Гүйцэтгэлийн хэмжүүр
- Тав. Шагналын төрөл, болзол
- Зургаа. Шагналд тодорхойлох
- Долоо. Шагналын тодорхойлолтыг хүлээн авах, шийдвэрлэх, гардуулах үйл ажиллагааны зохион байгуулалт
- Найм. Бусад
- Ес. Товчилсон нэр томъёо
- Арав. Холбогдох маягтууд
- Арван нэг. Өөрчлөлтийн тэмдэглэл

НЭГ.ЗОРИЛГО

Энэхүү журам нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын байгууллагын шагналд нэр дэвшүүлэх асуудлыг хүлээн авч судлах, шийдвэрлэх, гардуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

ХОЁР.ХАМРАХ ХҮРЭЭ

Журмыг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа төрийн болон төрийн бус байгууллага, иргэн, аж ахуй нэгж байгууллага дагаж мөрдөнө.

ГУРАВ.БАРИМТ БИЧГИЙН ХАРИУЦАГЧ

3.1.Баримт бичгийг Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн Хурлын бодлогын хэрэгжилт, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн хариуцна.

3.2.Энэхүү журмын хяналттай хувь Ажлын албаны дарга, Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга нарт байна.

ДӨРӨВ.ГҮЙЦЭТГЭЛИЙН ХЭМЖҮҮР

4.1.Хурлын байгууллагын шагналаар тухайн онд шагнуулсан иргэд, байгууллагын тоо

4.2.Журмын хэрэгжилтийн хувь

ТАВ.ШАГНАЛЫН ТӨРӨЛ, БОЛЗОЛ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагнал нь дор дурдсан төрөлтэй байна.

5.1.Эрдэнэт хотын "Хүндэт иргэн" цол тэмдэг, болзол

5.1.1.Эрдэнэт хотын “Хүндэт иргэн” цол тэмдэг нь Орхон аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын хамтарсан шагнал байна. Эрдэнэт хотын “Хүндэт иргэн” цол тэмдэг нь аймгийн ЗДТГ-ын шагналын журмаар зохицуулагдана.

5.2.“Оны тэргүүний ажилтан” тэмдэг, болзол

5.2.1.Орхон аймгийн “Оны тэргүүний ажилтан” шагнал нь аймгийн ИТХ, Засаг даргын хамтарсан шагнал байна.

5.2.2.Тухайн онд хөдөлмөрийн өндөр амжилт гаргаж, амжилт бүтээлээрээ салбараа хошуучилсан иргэнийг жил бүрийн эцэст шалгаруулах бөгөөд нэг иргэнд аймгийн ИТХ-аас 500,000(таван зуун мянга) төгрөгийн мөнгөн шагнал дагалдана.

5.2.3. Аймгийн ЗДТГ-ын шагналын журмаар зохицуулагдана.

5.3. “Цагаан арслан” цом, болзол

5.3.1.“Цагаан арслан” цом нь аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дээд шагнал байна.

5.3.2.Нутгийн удирдлагын байгууллага, орон нутгийн эдийн засаг, нийгэм, оюун санааны хөгжилд шинэ инновац, шинэ техник технологи нэвтрүүлэх, нутагшуулах, өндөр технологи шингэсэн шинэ бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг нэвтрүүлсэн, өөрийн улс болон дэлхийн хэмжээнд аймаг орон нутгийнхаа нэрийг гаргаж онцгой амжилт гаргасан, орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулсан байгууллага, иргэнийг шагнана.

5.3.3.“Цагаан арслан” цомоор жилд нэг удаа буюу сар шинийн баярыг тохиолдуулан 3 хүртэлх байгууллага, 1 иргэнийг шалгаруулах бөгөөд соёрхол, 2,000,000 (хоёр сая) төгрөгийн мөнгөн шагнал дагалдана.

5.4.”Иргэний төлөө” медаль, болзол

5.4.1.“Иргэний төлөө” медаль нь аймгийн ИТХ-ын дээд шагналын нэг юм. Энэхүү шагналаар аймаг орон нутгаа хөгжүүлэх, нутгийн өөрөө удирдах болон төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг бэхжүүлэх, нийгмийн дэг журам, хууль ёсыг хангах, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарт аймаг, орон нутгийн өмнө тулгамдсан зорилтыг шийдвэрлэхэд онцгой хувь нэмэр оруулж, үр бүтээл гаргасан иргэнийг шалгаруулж шагнана.

5.4.2.Орхон аймаг, Эрдэнэт хотод 18-аас доошгүй жил ажилласан байна.

5.4.3.“Иргэний төлөө” медаль нь үнэмлэх, 100,000 (нэг зуун мянга) төгрөгийн мөнгөн шагнал дагалдана.

5.5.“Хүндэт жуух бичиг” болзол

5.5.1.“Хүндэт жуух” бичиг нь аймгийн ИТХ-ын шагнал бөгөөд тухайн шагналаар аймаг, орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж идэвх зүтгэл гаргаж үр бүтээлтэй ажилласан иргэнийг шалгаруулж шагнана.

5.5.2.Орхон аймаг, Эрдэнэт хотод 5 ба түүнээс дээш жил ажилласан байна.

5.5.3.”Хүндэт жуух” бичигт 50,000 (тавин мянга) төгрөгийн мөнгөн шагнал дагалдана.

ЗУРГАА.ШАГНАЛД ТОДОРХОЙЛОХ

6.1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шагналаар шагнуулахаар дараах баримт бичгийн бүрдлийг ханган Ажлын албанд ирүүлнэ. Үүнд:

6.1.1. Байгууллагын албан хүсэлт

6.1.2. Шагналд тодорхойлох анкет

6.1.3.Хамт олны хурлын тэмдэглэл

6.1.4.Иргэний үнэмлэхийн хуулбар

6.2.Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн “Журам батлах тухай” 204 дүгээр тогтоолд заасан өдрүүдийг тохиолдуулан тухайн салбар, байгууллагын тэргүүний ажилтнуудыг шагнаж болно.

6.3.Аймаг, орон нутгийн бүтээн байгуулалтад гар бие оролцож, ажлын амжилт гаргасан гадаадын иргэн (албан ёсны оршин суух зөвшөөрөлтэй)-ийг шагнаж болно.

6.4.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн “Журам шинэчлэн батлах тухай” 5 дугаар тогтоолоор шалгарсан хамт олон, иргэнд 500,000 (таван зуун мянга) төгрөгийн хүндэтгэл үзүүлж болно.

6.5.Олон улсын тэмцээн, уралдаан, олимпиадад өндөр амжилт гаргасан баг, хамт олныг 2,000,000 (нэг сая) төгрөг хүртэлх, хүүхдийг 500,000 (таван зуун мянга) төгрөг хүртэлх мөнгөн шагналаар шагнаж болно.

6.6.Онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн, улс болон дэлхий нийтэд аймаг орон нутгийнхаа нэрийг гаргасан иргэнийг ажилласан жил, шагнал хоорондын хугацааг харгалзахгүйгээр шагнаж болно.

ДОЛОО.ШАГНАЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫГ ХҮЛЭЭН АВАХ, ШИЙДВЭРЛЭХ, ГАРДУУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1.Шагналд тодорхойлсон байгууллагуудын хүсэлтийг энэ журмын 6 дугаар зүйлийн 6.2-т заасан өдрүүдээс ажлын 10 хоногийн өмнө Ажлын албанд ирүүлнэ.

7.2.Ажлын албанд ирүүлсэн хүсэлтийг Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтэс хүлээн авч судалж, Хурлын дарга, Нарийн бичгийн даргад танилцуулна.

7.3.Аймгийн ИТХ-ын “Цагаан арслан” цомыг аймгийн ИТХ-ын байгууллагын удирдлагын зөвлөлийн хурлаар шийдвэрлэнэ.

7.4.Эрдэнэт хотын “Хүндэт иргэн”, “Оны тэргүүний ажилтан” шагналыг аймгийн ИТХ-ын Хурлын Зөвлөл, аймгийн Засаг даргын зөвлөл хамтарсан хурлаар олонхын санал авсан иргэнийг тодруулж шийдвэрлэнэ.

7.5.“Иргэний төлөө” медаль, “Хүндэт жуух бичиг” шагналыг аймгийн ИТХ-ын дарга шийдвэрлэнэ.

7.6.Шагналын асуудалтай холбоотой хүсэлтүүдийг багцлан сард нэг удаа аймгийн ИТХ-ын дарга захирамж гаргана.

7.7.Аймгийн ИТХ-ын шагналыг аймгийн хэмжээнд гардуулах шагналын нэгдсэн үйл ажиллагаанд гардуулна.

7.8.Шагнал гардуулах арга хэмжээг Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтэс зохион байгуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

НАЙМ.БУСАД

8.1.Аймгийн ИТХ-ын шагнал болон түүний үнэмлэхийг хаяж үрэгдүүлсэн тохиолдолд холбогдох хүсэлт (байгууллагын албан бичиг, иргэний өргөдөл, иргэний хуулбар)-ийг үндэслэн шийдвэрлэнэ.

8.2.Аймгийн ИТХ-ын шагнал хоорондын зай 5 жил байна.

8.3.Аймгийн ИТХ-ын шагналуудыг давхардуулан олгохгүй.

ЕС.ТОВЧИЛСОН НЭР ТОМЬЁО

ИТХ-Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ЗДТГ-Засаг даргын Тамгын газар

АРАВ.ХОЛБОГДОХ МАЯГТ

Маягт 1

ОРХОН АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ШАГНАЛААР ШАГНУУЛАХААР ӨРГӨН МЭДҮҮЛСЭН ХҮНИЙ АНКЕТ

1. Овог, эцэг /эх/-ийн нэр:
2. Өөрийн нэр:
3. Хүйс:
4. Боловсрол, мэргэжил:
5. Үндсэн захиргаа:
6. Боловсрол:
7. Ажилладаг салбар:
8. Татвар төлөгчийн дугаар:
9. Банкны дансны дугаар (өөрийн харилцах данс):
10. Урьд болон одоо ажиллаж байгаа газар:



| № | Ажлын газрын нэр | Эрхэлсэн ажил | Хугацаа |
|---|---------------------------|---------------|---------|
| 1 | | | |
| 2 | | | |
| | Нийт ажилласан жил | | |

11. Шагнагдаж байсан шагналууд:

| № | Шагналын нэр | Шагнагдсан он /заавал бичнэ/ |
|---|--------------|------------------------------|
| 1 | | |
| 2 | | |

12. Шагнуулах үндэслэл (гаргасан амжилт):.....

13. Ямар шагналаар шагнуулах хамт олны санал:

14. Хамт олны санал:.....

15. Шагналыг хүлээн авах /байгууллагын/ хариуцсан ажилтны нэр, утасны дугаар, мэйл хаяг:.....

Байгууллагын удирдах албан тушаалтан:.....(.....)
(тамга) (гарын үсэг)

АРВАН НЭГ.ЖУРМЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТЭМДЭГЛЭЛ

| Хувилбар | Өөрчлөлт оруулсан огноо | Өөрчлөлтийн утга | Өөрчлөлт оруулсан ажилтан |
|-------------|--|-----------------------------|--|
| 1 | 2 | 3 | 4 |
| Хувилбар -1 | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 2013.04.10 № 45 | Анх батлагдсан. | Ажлын албаны дарга |
| Хувилбар-2 | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 2015.01.29 № 09 | Шинэчлэн баталсан. | Ажлын албаны дарга |
| Хувилбар-3 | Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол 2016.10.04 № 114 | Нэмэлт, өөрчлөлт оруулсан . | Ажлын албаны дарга |
| Хувилбар-3 | Аймгийн ИТХ-ын даргын захирамж 2025.02.07 № А/16 | Шинэчлэн баталсан. | Бодлогын хэрэгжилт, иргэний оролцооны хэлтсийн дарга |

